

АШИГТ МАЛТМАЛЫН ЭРЭЛ, ХАЙГУУЛЫН ШИНЖЛЭХ УХААНЛАГ ХАНДЛАГА

Ж.Ган-Очир, П.Очирхуяг, Ц.Мөнгөншагай

1. Геологийн зураглал, ашигт малтмалын эрэл, хайгуул нь **бүхэлдээ эрдэм шинжилгээний хандлагатай байх** учиртайг. ашигт малтмалын эрэл, хайгуулын судалгааны удирдлага болгох,
2. Геологийн зураглал, ашигт малтмалын эрэл, хайгуулын **судалгааны үе шатыг** аль болохоор **баримтлах**,
3. Геологийн зураглал, ашигт малтмалын эрэл, хайгуулын судалгаа нь зөвхөн газар ухаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх төдий ажил биш, газар ухаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс өмнө хийгдэх **ашигт малтмалын эрэл, хайгуулын судалгааны бүхэл бүхэн үе шат** байдаг.

- - Дунд, том масштабын геозураглал, ерөнхий эрлийн судалгаатай дүйцэх хэмжээний геологи, эрлийн маршрут,
- - Талбайн шлихийн дээжлэлт,
- - Үндсэн чулуулгийн үйрмэг ба сэвсгэр хурдсын литогеохимийн дээжлэлт,
- - Геофизикийн хэмжилтийн иж бүрэн судалгаа,
- - Компьютерийн программ хангамжаар нэгтгэн дүгнэж боловсруулсан үр дүн - геологи, ашигт малтмалын зураг, зүсэлт, ашигт малтмалын тархалт, хэтийн төлөвийн зураг



Геологийн даалгавар



- Геологи, геохими, геофизикийн иж бүрэн шинжилгээ, сансар, агаар, газрын цогцолбор судалгааны мөн чанар, дэс дараалал, харьцаа, харьцуулалтын дүнд гарах үр дүнг урьдчилан тодорхойлсон, геологи, ашигт малтмалын судалгааны зорилго, мөн чанар, арга аргачлал, үе шатыг тодорхойлно.
- - судалгааны тухайн талбайн геологи, ашигт малтмалын тухай эх баримтыг бүрэн судалж, судалгааны чиг хандлаг, илрүүлж болох ашигт малтмалын төрөл, гарал үүсэл, байрлалын онцлог, судалгааны арга аргачлалыг тодорхойлох,
- - сансар, агаар, газрын судалгааны зураг мэдээлэл, эх баримтыг нэг бүрчлэн тайлж судлаад, нэгтгэн дүгнэж зураг, бүдүүвч боловсруулсаар судалгааны чиг баримжаа, арга аргачлыг тодорхойлно.



Төслийн геологи, ашигт малтмалын зураг

Ашигт малтмалын эрэл, хайгуулын төлөвлөлтийн зураг - Ашигт малтмалын эрэл, хайгуулын өмнөх судалгааны явцад боловсруулагдсан геологи хайгуулын хээрийн судалгааны ажил эхлэх “Нэвтрэх бичиг” болно.









- Ашигт малтмалын эрэл, хайгуулын өмнөх судалгааны дүнд сансарын зураг мэдээлэлд бүрэн шинжилгээ, геобүтэц, морфобүтцийн тайлал, боловсруулалт хийж гүйцэтгээд:
- - геоморфологи, морфобүтцийн зураг,
- - голын хөндийн зэрэглэлийн зураг,
- - голын хөндий, дэнжийн морфобүтцийн дагуу, хөндлөн зүсэлтүүд,
- - хагарал, ан цавын бүс, цагираг, нуман бүтцийн зураг боловсруулж,
- - алтны шижирмэг хуримтлал үүсэж болох морфобүтцийн онцлог байдал, шижирмэг хуримтлал үүсэх хуримтлалын муж, түүний хэлбэр, хэмжээ, голын хөндий, дэнжийн гадаргуугийн дагуу, хөндлөн налалтын (уналтын) хэмжээ, тунаш хуримтлалын зөөгдөх зай, усны хагалбар нутгийн геологи, геобүтцийн тогтоц, алтны шижирмэг хуримтлалын эх үүсвэр – алтны хүдэржил, хувиралын бүс, эрдэсжсэн цэгийн тогтоц, алтны хүдэржил – шижирмэг хуримтлалын холбоо,
- - геохими, геофизикийн иж бүрэн судалгааны тавил, тэдгээрийн хослол, дэс дараалал, харьцуулсан шинжилгээний дүнг нэгтгэж боловсруулах боломжтой болно.
- Геофизикийн иж бүрэн шинжилгээний дүнд голын хөндий, дэнж, уулын хажуугийн тогтоц, гүний хэмжээ, ул чулуулгийн гадаргуугийн байдал, голын хөндий, дэнж, хажуугийн хагарал, ан цавын бүсийн дагуу, тасарч шилжээд, шатлан тогтсон байдал, сэвсгэр хурдсын зузаан зэрэг асуудлыг судалж,
- - өрөмдлөг, уулын ажил тавих талбай, өрөмдлөг, уулын ажлын гүн, ажлын хэмжээг тогтооно.
- - Уул, өрөмдлөгийн ажлын “**Геологи-техникийн наряд**” боловсруулах,
- Хайгуулын шугамын дагуу өрөмдлөг, уулын ажил хослуулж тавих ашигт малтмалын эрэл, хайгуулын тавил шийдэгдэнэ.
- Геофизикийн шинжилгээний дүнд уулын хажуу, энгэр дэнжийн орчимд сэвсгэр хурдсын зузаан 2,0-4,0 м, 4,0-6,0 м ба хагарал, ан цавын бүсээр тасарч шилжээд 20,0-24,0 м ба зарим хэсэгтээ бүр 30,0 м доош сууж тогтсоныг тодорхойлсон дагуу цохилтот өрөмдлөгийн ажил тавьж судлах тавил боловсруулсан.
- Ашигт малтмалын эрэл, хайгуулын геологи, геохими, геофизик, сансар-агаар-газрын иж бүрэн судалгааны дүнд **алтны шижирмэг ордын бодитой, боломжтой нөөц тооцох**, дараа дараагийн судалгаа нөөц өсгөх үндэс болсон

- **Дүгнэлт**
- - Ашигт малтмалын эрэл, хайгуулын шинжлэх ухаанлаг энэ чиг хандлага бүх төрлийн ашигт малтмалын судалгаанд нэгэн адил хэрэглэгдэнэ,
- - Геологийн даалгавар -ын дагуу гүйцэтгэх ажлын төрөл, геологи, ашигт малтмалын эрлийн маршрут, геохимийн дээжлэлт, геофизикийн иж бүрэн хэмжилт, зураглал хийх, эс бол, өрөмдлөг уулын ажил явуулах зэргийг тодорхойлж, холбогдох зураг эх баримтаар баталгаажуулсан байх,
- - Төслийн геологи, ашигт малтмалын зураг,
- Ашигт малтмалын эрэл, хайгуулын төлөвлөлтийн зураг үнэн бодитой боловсруулах,
- - Сансар, агаар, газрын зураг мэдээлэл, өмнөх судалгааны эх баримтыг үндэслэх,
- - Өрөмдлөг, уулын ажил гүйцэтгэхийн өмнө, ашигт малтмалын эрэл, хайгуулын судалгааны өмнөх үе зайлшгүй,
- - Өрөмдлөг, уулын ажлын геологи-техникийн наряд боловсруулах,
- - Өрөмдлөг, уулын ажлын геологи-техникийн наряд – ын дагуу байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх байдлын хэмжээ, мөн чанарыг тодорхойлж, **“Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, нөхөн сэргээх хөтөлбөр”** боловсруулах,
- “Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, нөхөн сэргээх хөтөлбөр” – ийн байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө, мөн чанар, хэмжээнд тохирсон ажил гүйцэтгэх “Даалгавар” өгч **Байгаль орчны хяналтын бүх шатны арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвлөгөө** боловсруулж, хэрэгжүүлэх,
- Ашигт малтмалын эрэл, хайгуулын шинжлэх ухаанлаг энэ чиг хандлагыг судалгааны удирдлаг болгож хэрэгжүүлсэний дагуу “Геологи хайгуулын ажлын тайлан” боловсруулахдаа судалгааны тухайн талбайд илрүүлсэн **геологийн тогтоц, ашигт малтмалын шинэ олдвор, шинжлэх ухааны үр дүн, үр өгөөжийг** ихээхэн анхаарч тусгайлан тэмдэглэх,
- “Геологий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн холбоо”-г бэхжүүлэх,
- “Ахмад геологичдоос суралцах”, Бидний сайхан мэргэжил геологийн шинжлэх ухаан, геологичдын нэр хүндийг үргэлж өндөрт өргөж, “Геологичдын жинхэнэ амин холбоог бэхжүүлэх” ажилдаа амжилт олохыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

- Монголын геологийн албаны 70 жилийн ойдоо бэлэг барих геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажилдаа өндөр амжилт гаргаж, геологийн шинэ олдвор, ашигт малтмалын шинэ орд, томоохон илрэлүүд нээж илрүүлэх
е р ө ө л д э в ш ү ү л э э

Баярлалаа